


“ЭРХ ЧӨЛӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ” НАМ

УБ, СБДүүрэг, Шуудангийн 48 –р салбар, хайрцаг- 117
Утас: 99023883, 96697099, 99113439, 70112256, 91173439, 99094247, 88899751
E-mail: fredof_mn@yahoo.com,

ЭЧХН –н БЗХ – ны хурлаар

 батлав

2012.04.29.

Улаанбаатар хот

**Уриа: Эрх чөлөө ялна. Увайгүй улс төрчдийг 100%
Шинэчилье.**

ЗОРИЛГО: Эрхийн ч ялын ч эдлүүлье.

Мөрийн хөтөлбөр: “Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч” Нам мөрийн хөтөлбөрөө боловсруулахдаа Монгол Улсын Үндсэн хууль, сонгуулийн хууль болон бусад хуулийн хүрээнд улс орны өнөөгийн нөхцөл байдалд тохируулан бэлтгэж намынхаа төлөөлөн удирдах байгууллага БОЛОВСРУУЛАН ЗӨВЛӨЛДӨХ ХОРООГООР хэлэлцэн батлав. Мөрийн хөтөлбөрийг боловсруулахдаа “Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч” Намын нийгэмд эзлэх байр суурь Улсын Их Хуралд авч болох суудлын тоо, нийгэмд нөлөөлөх нөлөөлөл, авч явуулах арга хэмжээ түүний гүйцэтгэлд тооцоолон боловсруулсан болно.


Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам 2012 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрөө одоогийн нийгэмд бугьшсан бузар булай бусармаг үйлдэл, эмх замбараагүй байдлыг зогсоож, эх орны баялагаа хөрөнгө оруулалт нэрээр хөрш орнуудын болоод бусад орнуудын хамтын ажиллагаанд сэв суулгахгүй гэсэн хоцрогдсон сэтгэлгээгээр арилжааны бус гэрээ хийж ил далд зарах явдлаас ангижруулж, нэн яаралтай салгах, төрийн хүнд суртлыг устгах, улс төрчид, төрийн албыг авилгал, танил, төрөл ах дүүгийн арилжаанаас салгаж, сонгуулийг мөнгөнөөс, улс төрийг бизнесээс холдуулан иргэддээ үйлчилдэг төрийн бодлого явуулж, **Гадаадын /импортын/ бодлогыг халж, бодлогыг /экспортлоно/ бүтээгдэхүүн болгохоор** томъёолон боловсруулж Сонгуулийн Ерөнхий Хороо, Монгол Улсын үндэсний Брөнхий Аудитын газар, ард иргэддээ танилцуулж байна.



1. Иргэдээ дээдэлсэн төрийн бодлого явуулж, газар шороогоо хамгаална.

Төрдөө дээдлэгдсэн иргэдтэй, иргэддээ үйлчилдэг төртэй болгохын тулд юуны өмнө дараах цогц үйл ажиллагааг дэс дараатай явуулна.

- Улс орноо авилгал, хээл хахууль, хүнд суртал төрийн давхардсан орон тооны асуудал, бусармаг үйлдэл, эмх замбараагүй байдлаас салгаж, ард иргэдээ ядуурлаас ангижруулж, сонгуулийг луйвар мөнгөнөөс салгаж, улс төрийг бизнесээс салгаж, иргэдэд шууд үйлчилдэг шударга, хариуцлагатай, эрх тэгш, эрх чөлөөт засаглалыг бий болгоно.
- Иргэний нийгмийн байгууллагыг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх, бие даасан төрийн статустай болгож, иргэний байгууллагын нэрийн ард төрийн эрх мэдэлтний гар хөл бологч, төрд ажиллаж байгаад төрийн үйл ажиллагааг алдагдуулснаас төрөөс чөлөөлөгдөж, эргээд ТББ үүсгэн төрийн танилаар дамжуулан төрийн мөнгө идэж, хуваалцдаг Монгол Улсад шударга үйл ажиллагаа явуулж амьдрахад саад болдог танилын зам мөрийг хууль эрх зүйгээр хаах болно.
- Монгол Улсын Үндсэн хуульд заагдсан иргэн аюулгүй орчинд ажиллаж амьдрах, **хуулийн өмнө эрх тэгш** байх ёстой гэсэн зарчмыг биелүүлдэг, биелүүлэхийг ард түмэнтэйгээ хамт шаарддаг, тэмцдэг байх болно.
- Төр засгийг түрээсийн засаглалын байдлаас салгаж, жинхэнэ утгаараа Монгол Улсын төлөө үйлчилдэг Эрх чөлөөт, эрх тэгш, шударга, хариуцлагатай засаглалыг бий болгох зорилготой ажиллана.
- Иргэдийг улс төрийн ба Иргэдийн төлөөлөлийн байгууллагаа зөв сонгож сурах үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх зорилгоор хууль сурталчилах таниулах ажлыг орон даяар зохион байгуулна.
- Төрийн хүнд сурталыг арилгах зорилгоор төрийн албан хаагчдын ажлын үнэлгээг оффис, цаасан дээр үнэлдэг биш бодит байдалд ойртуулж, олон төрлийн зөвшөөрлийг устгах, нийтийн үйлчилгээний эрхийг иргэд авахдаа Мэргэжлийн хяналтын аль нэг газар ирж бүртгүүлж эрх авахын төлөө дугаарлан зогсох биш, цахим хуудсаар /интернет/ мэдээллээ эрх бүхий байгууллагад явуулж, эрх бүхий байгуулага ирж шалган эрхийг олгосноор ажлыг нь дүгнэдэг хууль эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- Хүний оролцоогүй төрийн үйлчилгээг бий болгоно. Өнөөдөр төрийн үйлчилгээг авахдаа иргэд хүнээс юм авах гэж байгаа юм шиг бий болсон хүнд суртлын үйлчилгээг халж, иргэд төрөөс авах ёстой зайлшгүй үйлчилгээг хэн нэгэн хүнд сурталтай албан хаагчийн гар ам харж олон шат дамжлага хүлээж цаг хугацаа алддаг, эдийн засгийн хувьд молигоддуулдаг биш иргэний шууд үйлчилгээг авдаг байх ёстой гэсэн зарчмыг төрийн үйлчилгээнд хэвшил болгоно.



- Өнөөгийн Монголын төрд улс, эх орон, иргэдийн төлөө биш намын бодлого давамгайлж, хэт намчирхсан үзэл газар авч, харин ард иргэдийн дуу хоолой болж чадах, тэдний сэтгэлийг ойлгодог улс төрч, иргэдийн төлөө зүтгэх зүтгэл, хэлж ярих дуу хоолой маш их дутаж байгаа учир түүнийг нөхөж чадах иргэдийн шудрага төлөөлөл үгүйлэгдэж байгааг ажил хэрэг болгох, зах зээлийн эрх зүйн орчинг богино хугацаанд төрийн бодлогод суурьшуулна.
- Төр иргэдийн бизнесд хутгалддагийг зогсоож төрийн бодлогын зохицуулалтыг бий болгож, төрийн зохих ёсны үйлчилгээг иргэддээ үзүүлдэг эрх зүйн орчинг сайжруулан зөвшөөрөл нэрийн дор иргэдэд учирдаг саад бэрхшээлийг халж, төрийн нэрийн өмнөөс явуулдаг сонгон шалгаруулалтыг /тендэр/ цэгцэлж үйл ажиллагааг нь ил тод болгоно.

2. Эдийн засгийн эрх чөлөөг иргэддээ бодитоор эдлүүлнэ.

- Гадаадын хөрөнгө оруулагч нар Монголын байгалийн баялагийг Монголчуудад ямарч ашиггүйгээр цөлмөдөг, хувьцаа хэлбэрээр арилжаалдаг, наймаалцдаг өнөөгийн хууль эрх зүйн цоорхойд хаалт хийнэ.
- “Та зочин бид эзэн нь байя” гэсэн зарчмаар монгол улсад төрийн айлчлал, хөрөнгө оруулалт хийх, ажиллаж, амьдрах, аялал жуулчлалаар ирэгсэд зочны хэмжээнд байж, монгол улсын иргэнээс дээгүүр эрх ямба эдэлдэггүй байх зарчмыг бий болгож хэрэгжүүлнэ. Өөрөөр хэлбэл бид гадныханд зарцлагдах биш тэдний оюуны нөөцийг ашиглаж байгалийн болон хөдөө аж ахуйн баялагаа ашиглан иргэн бүр тэгш баяжих зарчим баримтлана.
- Цаашид гадныхан Монгол оронд аж ахуйн үйл ажиллагаа явуулахдаа дураараа авирладаг, Монголчуудын ажлын байрыг эзэмшдэг, булаадаг эрх зүйн орчинг хязгаарлаж зогсоох болно.
- Зах зээлийн өрсөлдөөнийг жинхэнэ утгаар нь бий болгож, жижиг дунд үйлдвэрлэлийг бодитоор дэмжиж, иргэн өөрсдийнхөө өдөр тутмын эдийн засгийн шаардлагыг хангаж чаддаг бодлогыг төрийн бодлогод нутагшуулах зорилгыг баримтална.
- Гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдийн эрх зүйн орчинг эрүүлжүүлэх зорилгоор гадаадад ажиллаж, амьдарч байгаа Монголчуудын эрх ашгийг бүх шатанд элчин сайдаар нь дамжуулан бодитоор хамгаалдаг төрийн механизмыг хуульчлан суулгана.
- Хүний хөдөлмөрийн хөлсийг цагаар, бүтээгдэхүүнээр нь үнэлдэг тогтолцоонд шилжүүлбэ.
- Төрийн албаны зөвлөлийн бодлогыг өөрчилнө. Өнөөгийн төрийн албаны тогтолцоог үндсээр нь өөрчилж намын нөхөд, танил тал ах дүү нараар дүүргэсэн хувийн эрх ашгийн албанаас салгана. Жинхэнэ утгаараа иргэдэд, нийтэд эх орны нэрийн өмнөөс үйлчилдэг жишигийг

тогтооно. Хүний хөдөлмөрийн хөлсийг цагаар, бүтээгдэхүүнээр нь үнэлдэг тогтолцоонд шилжүүлбэ.

- Дотоодын үйлдвэрлэлээ дэмжих зорилгоор хүн бүр үйлдвэрлэгч байх ёстой гэсэн ойлголтыг иргэн хүний сэтгэл зүйд суулгаж, үйлдвэрлэл эрхлэх эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ.

3. Баян хоосны ялгааг ойртуулж баялагийн хувиарлалтыг жигд хийж, тэнэмэл хүүхдүүдэд төрийн бодлогын санхүүгийн бус дэмжлэг үзүүлэнэ.

Байгалийн баялаг, ашигт малтмалын үр өгөөжийг нийт ард түмэнд үр өгөөжтэй, тэгш хуваарилалтыг бий болгох зорилгоор "Ашигт малтмалын тухай хуулинд" дараах нэмэлт өөрчлөлт оруулна.

- Ашигт малтмалын зөвшөөрөл /лиценц/ олголтын тоог хязгаарлах зорилгоор хуульд зах зээлийн баримжаатай өөрчлөлт суулгана.
- Нөхөн сэргээлтийн төлбөрийг урьдчилан Улсын төсөвт төвлөрүүлдэг, хөрөнгө нь хүрэхгүй байхаас сэргийлэх зорилгоор эд хөрөнгийг нь барьцаанд авдаг эрх зүйн орчинг хуулинд суулгаж хэрэгжүүлнэ.
- Стратегийн ач холбогдолтой уул уурхайг төрийн эрх мэдэлд онцгойлон авч, нөөцийг тогтоож, кадастрийн зураглал гаргуулж, олон улс болон дотооддоо сонгон шалгаруулалт нээлттэй явуулж, нөөцийн нийт үний дүнгийн 60% - г урьдчилан улсын төсөвт оруулсны дараа шалгарсан байгууллагад нь 9 хүртэлх жилээр ашиглалтын зөвшөөрөл олгодог болгоно.
- Эх орны баялагаа үр ашиггүй зарж, лицензи дамлан наймаалагчдад эрүүгийн онц хүнд зүйл ангилалд хамааруулан ялладаг, хууль бус хөрөнгийг хураадаг хуулийг яаралтай баталж хэрэгжүүлнэ.
- Стратеги орд газрыг гадаадын хөрөнгө оруулагчдад ашиглуулах, эзэмшүүлэх өнөөгийн арга барилыг үндсээр нь өөрчилж хөгжингүй орны жишгээр урьдчилгааг өөрийн орны үндсэн дансанд шилжүүлдэг жишиг тогтооно.
- Тэнэмэл ба асрамжийн хүүхдийн тоог олширохоос сэргийлж, тэднийг төрийн тусгай хангалттай сургуульд /Энэ нь одоогийн Дотоодын Хэргийн Их сургуульд/ суралцуулж мэргэжилтэй болгох, нийгэмшилд нь тусгайлан анхаардаг бодлого боловсруулж, *цаашид эх орныхоо төлөө тогтвортой ажиллах гэрээний эрх зүйн шинэ орчинг бий болгоно.*
- **Зэвсэгт хүчний талаар:** Үндэсний зэвсэгт хүчинг хүчирхэг болгох бодлогыг үндэсний эрх ашиг болон олон улсын гэрээ конвенцид нийцүүлэн явуулна.

4. Тэтгэврээс завсардагсдад өршөөл үзүүлэх тухай хууль гаргана.

- Монгол улс 1990 оноос зах зээлд шилжин орох хөдөлгөөнд орж, өөрөөр хэлбэл иргэдээс шалтгаалсан гэхээсээ илүүтэйгээр дэлхийн нийт зах зээлийн тогтолцоо руу шилжиж, социализмын бодлогоор амьдарч байсан ард түмнийг чөлөөт зах зээлийн нийгэмд шилжүүлэх үйл ажиллагаанд оруулсан явдал юм. Энэ үед одоогийнхоор төрийн, тэр үеийн нэршлээр улсын байгууллагад ажил эрхэлж байсан мянга мянган хүмүүс ажлаа орхин хувийн арилжаа наймааны хэлбэрт шилжснээс үүдэн нийгмийн даатгалын хураамжаас 50, 60, 70 – д оныхон завсардсан нь төрийн бодлогын буруутайгаас болсон гэж үзэж тэдгээрийн эрх ашигт нийцсэн хууль эрх зүйн зохицуулалт хийнэ.

5. Эрүүл мэндийн даатгалын эрх эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ..

- Эрүүл мэндийн даатгалын жинхэнэ утгаараа иргэдэд үйлчилдэг механизмыг хуульчилна.
- Иргэн эрүүл мэндийн даатгалыг эдийн засгийн эргэлтэнд оруулдаг болгох хуулийн төслийг санаачилан батлуулана.
- Хүн амаа өсгөх эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ.
- Эрүүл мэндийн олон төрлийн даалтгалд хамрагдах эрх зүйн орчинг бий болгоно.

6. Гадаадын /импортын/ бодлогыг халж, бодлогыг /экспортлоно/ бүтээгдэхүүн болгоно.

- Монгол улсын тусгаар тогтнолд сөргөөр нөлөөлөх гадны импортын бодлогоос иргэдтэйгээ хамтран татгалзаж чаддаг жишиг тогтоож, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг орон даяар зохион байгуулна.
- Төрийн бодлогын үйл ажиллагаанд гадныхны гар хөл орж байгааг хуулиар хориглож, дотоодын бодлогоо бүтээгдэхүүн болгож экспортолдог болгоно.
- Импортын бодлогыг халж, бодлогыг экспортлож, зах зээлийг гадны хараат байдлаас салгана. Өнөөгийн төр засаг эх орны хөрсөнд тохирсон бодлого баримтлах биш гадны нөлөөнд автсан бодлого явуулж байгааг таслан зогсоож хална, ард түмний эрх ашигт нийцсэн бодлогыг боловсруулан бүтээгдэхүүн болгож экспортолдог зарчим баримтлана.

7. Түрээсийн тухай хууль санаачилж хэрэгжүүлэх, хувиараа хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэрийн эрх зүйн орчинг тааламжтай болгоно.

Жижиг дунд үйлдвэрийн тухай 2007 оны хуулийг шинэчлэн найруулж одоогийн эдийн засгийн чадамжтай уялдуулан сайжруулах, амьдралд бодитоор хэрэгждэг болгоно.

- Монголчуудын 70 –с доошгүй хувь нь хувийн бизнес хийж түрээсээр амьдардаг. Гэтэл өнөөг хүртэл түрээслэгч түрээслүүлэгчийн аль алины эрх ашгийг хамгаалсан зах зээлийн баримжаатай хууль ус агаар мэт хэрэгтэй байгааг шийднэ.
- ХАА, МАА, газар тариалан, дэд бүтэц, барилга хот байгуулалтын салбарт бизнес эрхлэгчид өөрсдийн хүсэл ашиг сонирхолын үүднээс сүүлийн үеийн төхник технологи нэвтрүүлэх эрх зүйн орчинг нээлттэй болгоно.
- Жижиг дунд үйлдвэрт биотехнологи, нанотехнологийг нэвтрүүлэх шинэ хууль санаачилж санхүүгийн бус төрийн бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- Хөгжингүй орнуудад жижиг дунд үйлдвэрийн төлөөллийн газар байгуулж улс хоорондын ажил төрлийн нягт холбоо тогтооно.
- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор 4 жил тутамд үндэсний хөтөлбөр баталж, үр дүнг тооцдог аргачиллыг суулгаж өгнө.
- Жижиг дунд үйлдвэрийг бүсчлэн хөгжүүлэх, малчдын хамтарсан хувьцаат аж ахуйн нэгжүүдийг өөрсдөө сайн дурын үндсэн дээр байгуулах таатай орчинг бүрдүүлж өгнө.

8. Газар олголтыг ил тод болгож, цахим тогтолцоонд /онлайн/ шилжүүлнэ.

- Газар олгох үйл ажиллагааг онлайн сүлжээнд шилжүүлснээр иргэд хаана ямар хэмжээний газар байгааг гэрээсээ мэдэж болдог, газрын лавлагааг өргөдөл өгсөн үедээ авдаг, газар олголтыг иргэдэд тэгш хуваарилах зарчимтай болгоно. Улаанбаатар хотыг утаанаас салгах зорилгоор олон талт арга хэмжээг авч явуулахдаа дэд бүтэцийн асуудлыг эхний ээлжинд шийднэ. Нийслэлийн цагдаагийн хэв журмын хэлтэстэй хамтран хотыг хогноос салгах цогц арга хэмжээг авч явуулна.
- Улаанбаатар хотын гудамжинд хог хаясан байгууллага, айл гэр бүл, хувь хүмүүст торгуулийн арга хэмжээ авч ажиллах эрхийг хэв журмын цагдаад шилжүүлнэ.
- Дүүргүүдийн Тээвэр үйлчилгээний компанийг хувийн хэвшилд шилжүүлэх хуулийн төслийг санаачлан УИХ-д оруулж, хогний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийг дэмжиж ажиллана.

- **Орон сууцжуулах талаар:** Төрөөсөө баримталж байгаа бодлогын 6% -н хөнгөлөлттэй зээлийг үргэлжлүүлэх боловч зарим заалтыг зах зээлжүүлэнэ. Энэ бодлогын ард явагдаад байгаа мөнгө угаах үйл ажиллагааг зогсооно. ОССК тавигдаж байгаа барилгын компани шалгаруулдаг, өмнө нь орон сууц хамтран эзэмшигч байсан гэсэн заалтанд ялгаа гаргах, иргэд онцгойлон заасан барилгын компаниас орон сууц авах биш шинэ хуучин хаанаас ч өөрсдөө сонгох боломж олгох гэх мэт шаардлагуудад өөрчлөлт оруулах болно. Өөрөөр хэлбэл иргэддээ зах зээлийн журмаар орон сууцжуулах асуудлыг төрийн бодлогын баримт бичигт суулгаж өгнө.

9. Сонгон шалгаруулалт /тэндер/ - аар баяжигсад, иргэдийн татварыг хулгайлдаг үйлдлийг хааж, төрийн өндөр албыг хулгайчаар /олигархи/ дүүргэдэг асуудлыг таслан зогсооно.

- Хэрэв "Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч" нам УИХ-д суудалтай болвол УИХ-н гишүүний үндсэн үүргийн дагуу хуулийн гүйцэтгэлд хяналт тавих үйл ажиллагаагаа эрхийнхээ хүрээнд эрчимжүүлж, төрийн байгуулагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд өөрсдийн санаачилгаар болон иргэдийн хүсэлтийн дагуу хяналт, шалгалт хийх, хийлгэх ажлыг цаг алдалгүй эрчимтэй явуулах болно.
- Ард түмний хүнсний үндсэн хэрэглээ махны бодлого боловсруулахдаа махыг дотоод, гадаадын иргэд чөлөөтэй бэлтгэн авдаг эрх зүйн орчноор нэгэн адил хангаж, харин улсын хилээр гаргахад нь хориг тавих, хууль бусаар гаргасан тохиолдолд оролцогчдыг эрүүгийн хариуцлагад татаж, эдийн засгийн өндөр торгууль ноогдуулдог болгоно.
- Хүн ардыг зөв хооллож эрүүл амьдруулах нөхцөлийг хангах, иргэд өөрсдөө махаа бэлтгэхэд нь дэм болох зорилгоор гахай тахианы аж ахуй эрхлэгчдийг төрөөс хууль эрх зүйн бодлогоор дэмжиж, Монгол улсын хилээр тахиа, гахайны махыг хилээр нэвтрүүлэхийг хориглосон тусгай зөвшөөрлийг цуцалж ард иргэдийг бүх төрлийн махан бүтээгдэхүүнээр хангана.
- *Махны жижиг үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж, зах зээлд гаргахад нь төрийн бодлогын туслалцаа үзүүлэх, бусад арга хэмжээ авах, чөнжүүд өөрсдөө малчдын хотноос мал бэтгэлээ хангадаг эрх зүйн орчинг бүрдүүлж өгнө.*
- Улсын нөөцын мах бэлтгэдэг үйл ажиллагааг зогсоож аж ахуй нэгж, иргэд өөрийн хэрэгцээнийхээ махыг бэлтгэж хадгалдаг хууль эрх зүйн орчинг бий болгоно.
- Улаанбаатар хотод мах тээвэрлэн оруулахад учирдаг бэрхшээлийг арилгана. Өөрөөр хэлбэл хот руу малчдын ба малчдаас бэлтгэсэн мах нэвтэрхэд тавигдсан хориг бүхий хууль тогтоомж, журмыг цуцална.

- Цагаан будааны үйлдвэрлэлийг бий болгож дотоодын хэрэгцээнийхээ тодорхой хувийг хангаж, цаашид эх орондоо тариалалтыг эхлүүлэнэ.

Мөрийн хөтөлбөрийн товчоо.

1. Иргэдээ дээдэлсэн төрийн бодлого явуулж, газар шороогоо хамгаална.
1. Эдийн засгийн эрх чөлөөг иргэддээ бодитоор эдлүүлнэ.
2. Баян хоосны ялгааг ойртуулж баялагийн хуваарилалтыг жигд хийж, тэнэмэл хүүхдүүдэд төрийн бодлогын санхүүгийн бус дэмжилэг үзүүлнэ.
3. Тэтгэврээс завсардагсад өршөөл үзүүлэх хууль гаргана.
4. Эрүүл мэндийн даатгалын эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ.
5. Гадаадын /импортын/ бодлогыг халж, бодлогыг /экспортлоно/ бүтээгдэхүүн болгоно.
6. Түрээсийн тухай хууль санаачилж хэрэгжүүлэх, хувиараа хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэрийн эрх зүйн орчинг тааламжтай болгоно.
7. Газар олголтыг ил тод болгож, цахим тогтолцоонд /онлайн/ шилжүүлнэ.
8. Сонгон шалгаруулалт /тэндер/ - аар баяжигсад, иргэдийн татварыг хулгайлдаг үйлдлийг хааж, төрийн өндөр албыг авлигачидаар /олигархи/ дүүргэдэг асуудлыг таслан зогсооно.

“Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч” Нам нь 2012 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцох зорилгоор мөрийн хөтөлбөрөө бэлтгэхдээ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай /2011 оны 12.15 ны/ өдөр батлагдсан хуулийн 34.1 – д заасан сонгуулийн мөрийн хөтөлбөрт мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгөтэй холбогдсон эрх олгох, уул уурхай газрын тос, эрдэс баялагийн болон бусад салбарын орлогоос иргэдэд аливаа хишиг, хувь, тэдгээртэй адилтгах бусад зүйл хүртээх, эсхүл зээлийн болон бусад өр төлбөрийг хүчингүй тооцох, хөрвүүлэх, эсхүл ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт авахаар тусгахыг хориглоно гэсэн хуулийн заалтанд яв цав нийцүүлэн боловсруулсан болно.

“Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч” Нам нь 2012 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцох зорилгоор мөрийн хөтөлбөрөө боловсруулахдаа Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн тухай хуулийн 34.6 . Сонгуульд олонхи суудал авсан нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь тухайн сонгуулийн үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурлаас байгуулах Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үндэс болно гэсэн заалтыг баримталсан болно.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн тухай хуулийн 34.4 . Нам эвслийн мөрийн хөтөлбөрт санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээ

тусгагдсан тохиолдолд түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцсэн байна гэсний дагуу "Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч" Нам нь 2012 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцох зорилгоор боловсруулсан мөрийн хөтөлбөртөө шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн тооцоог Монгол Улсын Үндэсний Ерөнхий Аудитын газраас Улс төрийн намуудад хүргүүлсэн удирдамж, заавар зөвлөмжийн дагуу "Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч" Намаас 2012 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцох зорилгоор боловсруулсан мөрийн хөтөлбөртөө тусгагдсан санхүүгийн эх үүсвэр шаардагдах хэсэгт тус байгуулагаас ирүүлсэн хувилбаруудын хэсгээс "ХУВИЛВАР - А" –г "Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч" Намын өнөөгийн цаг үеийн нөхцөлд тохируулан боловсруулсан мөрийн хөтөлбөрт нийцэх үндэслэлтэй гэж үзэж байгаа ба төсвийн суурь түвшинд үндэслэн тооцсон гол нэр төрлийн эрдэс баялагийн бүтээгдэхүүн, тэдгээрийн үнэ, орлогын тооцоолол, төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тэнцлийн үзүүлэлтүүд болоод макро эдийн засгийн төсөөлөлтэй нийцэлтэй байгаа бөгөөд холбогдох тооцооллыг өөрчилөн хийх шаардлагагүй гэж үзэж **ХАВСРАЛТ 1** ба **ХАВСРАЛТ 2** –г бэлтгэсэн болно.

**ЭЧХН-н Боловсруулан зөвлөлдөх хороо,
Улс төрийн бодлогын зөвлөл.**

НАМЫН ДАРГА


ШООВДОРЫН ТӨМӨРСҮХ

**Боловсруулан Зөвлөлдөх Хороо,
Улс Төрийн Бодлогын зөвлөлийн гишүүд**

ЦОГЗОО ХҮРЭЛБААТАР

ДАВААСҮРЭН АДЪЯАЦЭРЭН

